



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn

2018.02.14 № 67

танай _____ -ны № _____ -т

Г ү ДУНДГОВЬ АДААЦАГ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА С.ОТГОНБАЯР ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Адаацаг сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд албан шаардлагыг хүргүүлж байна.

Хавсралт хуудас

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР 
П.ТӨВСАННАА

D:\office\Alban bichig\A5\Хүргүүлэх тоот.docx



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 14

№ 01/24 04A-2018/18/СМ-ТЦ Мандалговь хот

Г

Зөрчил арилгуулах тухай

Т

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Адаацаг сумын Эрүүл мэндийн төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аudit хийх явцад нийт 14,049,980.00 /арван дөрвөн сая дөчин есөн мянга есөн зуун наян/ төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн төсвөөс гэрээт ажилтнуудын нийгмийн даатгалын шимтгэлийг төлж, нийт 1,161,434.00 /иэс сая нэг зуун жаран нэгэн мянга дөрвөн зуун гучин дөрвөн/ төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, Сангийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 14-ний 55 дугаар тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”-ын ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн тайлбар хэсэгт /... үндсэн болон нэмэгдэл цалин, түүнтэй адилтгах орлогоос төлөх нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг тооцож энэ ангилалд бүртгэнэ. Эдгээр зардлыг бүлгийн дүнгээр хянана/ заасныг тус тус зөрчсөн байна.

2. Гэрээт ажилтанд үр дүнгийн урамшуулалт цалин олгож, нийт 1,097,196.00 /иэс сая ерөн долоон мянга нэг зуун ерэн зургаан/ төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 150 дугаар тогтоолоор батлагдсан "Эрүүл мэндийн төвийн ажилтанд нэмэгдэл, мөнгөн урамшуулалт олгох журам"-ын 1.2-т /Нэмэгдэл болон мөнгөн урамшилыг торийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад ажилласаж байгаа эрүүл мэндийн ажилтанд олгоно. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага энэхүү журмын дагуу нэмэгдэл, мөнгөн урамшил олгох болно/ заасныг зөрчсөн байна.

3. Шатахууны зарцуулалтын тооцоог бодоогүй, акт үйлдэж баталгаажуулаагүй 11,791,350.00 /арван нэгэн сая долоон зуун ерэн нэгэн мянга гурван зуун тавин/ төгрөгийг зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т /батлагдсан төсөв, хотолбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлон захирагчтай байгуулсан гэрээний

хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/, Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалын 1-р хавсралтад /Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жисийг нормыг үндэслэн тогтоож, мөрдөж ажиллах, шатахууны зарцуулалтын тооцоог тогтсон хугацаанд бодож, тооцоо бодсон актыг үйлдээж баталгаажуулах/ заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д /Аудитын явцад илэрсэн толбор, зорчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрхзүйн хэмжээс тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн толборийг барагдуулах, зорчлийг арилгуулах зорилгоор толбөрийн акт, албан шаардлага өгөх/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1.1-д /Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлоогүй/, 4.1.3-т /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зорчсөн/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, дээрх зөрчлүүдийг таслан зогсоох;
 2. Шатахууны тооцоо бодох, зарцуулалтанд хяналт тавих;
 3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2018 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Адаацаг сумын Эрүүл мэндийн төвийн дарга С.Огтонбаяр, нягтлан бодогч Б.Энхжаргал наарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ



ΕΙΣΘΗ

АУДИТОР

ЖУГТАХБА ЯР

ЗӨВШӨӨРСӨН:

ДАРГА

С О Т Г О Н Е Б А Я Р

НЯГТЛАН БОЛОГЧ

БЭНХЖАРГАЛ

¹Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зорчил гаргасан албан тушаалтанд ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хургуулна/